

Ипотекийн зээлийн тайлан

2014 оны 9 дүгээр сар

Банкууд 2014 оны 9 дүгээр сард нийт 1872 зээлдэгчид 92.1 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгосноор банкуудын ипотекийн зээлийн үлдэгдэл 2619.2¹ тэрбум төгрөг, нийт зээлдэгчдийн тоо 62017-т хүрчээ.

Тайлант сарын эцэст банкуудын ипотекийн зээлийн үлдэгдлийн жилийн өсөлтийн хурд өмнөх сартай харьцуулахад 12.2 нэгж хувиар, оны эхнээс 66.9 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 42.2 нэгж хувиар буурсан байна.



Банкуудын ипотекийн зээлийн үлдэгдлийн нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр” (ОСИСТТБХ)-ийн хэрэгжилттэй холбоотойгоор 2013 оноос эхлэн эрс нэмэгдсэн байна.



Тайлант сарын эцэст банкуудын ипотекийн зээлийн үлдэгдлийн 70.0 хувь буюу 1833.5 тэрбум төгрөгийг “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээл (жилийн 8 хувийн хүүтэй зээл болон 8 хувийн хүүтэй зээлд шилжүүлсэн зээл), 27.3 хувь буюу 714.9 тэрбум төгрөгийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 2.7 хувь буюу 70.8 тэрбум төгрөгийг бусад эх үүсвэрээр олгосон зээл бүрдүүлж байна.



¹ МИК-т шилжүүлсэн зээлийн дүн орсноор.

2014 оны 9 дүгээр сарын байдлаар ипотекийн зээлийн үлдэгдлийн 97.9 хувь нь төгрөгийн зээл, 2.1 хувь нь гадаад валютын зээл байна.

Ипотекийн зээлийн үлдэгдэлд эзлэх хугацаа хэтэрсэн зээлийн хувь 2014 оны 9 дүгээр сарын байдлаар 1.0 хувь, чанаргүй зээлийн эзлэх хувь 0.5 байна.



Тайлант сард олгосон зээл

Тухайн сард олгосон ипотекийн зээл өмнөх сараас 4.1 хувиар өссөн ч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 47.8 хувиар буурсан байна.



Тайлант сард шинээр олгосон зээлийн 67.1 хувь буюу 61.8 тэрбум төгрөг нь “Орон

сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээл, 32.9 хувь буюу 30.3 тэрбум төгрөг нь банкуудын өөрийн эх үүсвэрээс олгосон зээл байна.

Нэг зээлдэгчид ногдох олгосон зээлийн хэмжээ 2014 оны 9 дүгээр сарын байдлаар 49.2 сая төгрөг байна.



Тухайн сард 27.6 тэрбум төгрөгийн ипотекийн зээл төлөгдсөн нь өмнөх сараас 10.4 хувиар өссөн ч өмнөх оны мөн үеэс 7.4 хувиар буурсан байна.




Зээлдэгчдийн тоо

Тайлант сард нийт 1872 иргэн шинээр ипотекийн зээлд хамрагдсанаас 1117 иргэн “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээлд, 755 иргэн банкны өөрийн эх үүсвэрийн зээлд хамрагдсан байна.



2014 оны 9 дүгээр сарын байдлаар нийт 62017 иргэн ипотекийн зээлтэй байгаагаас 41390 нь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээлд, 18569 нь банкуудын өөрийн эх үүсвэрийн зээлд, 2058 нь бусад эх үүсвэрийн зээлд хамрагдсан байна.

Нийт зээлдэгчдийн тоо болон сарын өсөлт




Зээлийн хугацаа

Тайлант сард банкууд 0.5-20 жилийн хугацаатай зээл олгосон бөгөөд жигнэсэн дундаж хугацаа нь 15.5 жил байна. Ипотекийн зээлийн үлдэгдлийн жигнэсэн дундаж хугацаа 2014 оны 9 дүгээр сарын байдлаар 14.8 жил байна.

Тухайн сард олгосон зээлийн дийлэнх буюу 46 хувь нь 16-20 жилийн хугацаатайгаар олгогдсон. Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 42.5 хувь нь 11-15 жил, 37 хувь нь 16-20 жил, 17 хувь нь 6-10 жил, 3.5 хувь нь 1-5 жилийн хугацаатай байна.

Ипотекийн зээл, хугацааны ангиллаар



Зээлийн хүү

Банкуудын 2014 оны 9 дүгээр сард олгосон ипотекийн зээлийн хамгийн өндөр хүү нь жилийн 25.8 хувь, хамгийн бага нь 3.6 хувь байсан бөгөөд тухайн сард олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү 10.6 хувь байв. “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр” хэрэгжиж эхлэхээс өмнөх үетэй харьцуулахад жигнэсэн дундаж хүү 6 нэгж хувиар буурсан байна.



Банкуудын өөрийн эх үүсвэрээр төгрөгөөр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 15.8 хувь байв.

Хавсралт 1. Банкуудын ипотекийн зээлийн тайлан

Он	Сар	Ипотекийн зээлийн үлдэгдэл (сая төг.)	Үүнээс:	Тайлант сард шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хугацаа (сараар)	Тухайн сард олгосон зээлийн ЖДХҮҮ, жилээр (%)	Нийт зээлдэгч (тоогоор)	
			ОСИСТГБ хөтөлбөрийн зээл				
2008	12	217,977.5		100.7	19.8	16,522	
2009	12	226,040.6		103.4	18.7	16,784	
2010	12	333,776.6		115.0	16.0	19,700	
2011	12	669,662.8		154.3	14.8	26,869	
2012	12	845,204.4		155.5	15.3	29,887	
2013	1	856,633.6		149.1	17.0	29,683	
	2	873,666.4		156.1	16.8	29,946	
	3	903,557.5		158.6	15.7	30,419	
	4	944,516.8		155.4	15.8	31,412	
	5	986,182.2		147.8	16.6	32,247	
	6	1,032,156.7		276,328.4	168.3	12.9	33,028
	7	1,273,003.6		553,346.9	202.4	9.2	37,751
	8	1,461,753.4	781,483.2	207.6	8.9	40,596	
	9	1,611,383.8	943,976.7	206.0	9.1	42,968	
	10	1,750,781.6	1,076,924.5	193.9	9.6	45,138	
	11	1,834,042.7	1,155,409.2	192.8	9.7	46,482	
	12	1,938,945.3	1,248,633.8	192.8	9.9	48,320	
2014	1	2,021,424.9	1,324,898.9	194.4	9.8	49,731	
	2	2,121,802.6	1,382,084.1	193.2	9.9	53,611	
	3	2,193,368.6	1,451,938.1	190.7	9.9	54,787	
	4	2,280,503.5	1,538,506.8	192.1	9.8	56,137	
	5	2,365,349.5	1,618,127.2	189.3	10.0	57,579	
	6	2,440,007.1	1,684,583.9	182.3	10.5	58,793	
	7	2,492,105.2	1,728,222.8	187.9	10.7	59,756	
	8	2,553,827.2	1,780,078.3	186.7	10.5	60,851	
	9	2,619,161.1	1,833,494.0	185.9	10.6	62,017	